

Төсөл

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2.Цагдаагийн байгууллага нь энэхүү журмыг өөрийн эрх хэмжээний хүрээнд дагаж мөрдөнө.

1.3.Аюулын зэргийн үнэлгээг гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу хүчирхийлэл үйлдэгдсэн газарт очсон цагдаагийн алба хаагч хийнэ.

1.4.Аюулын зэргийн үнэлгээ хийхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг баримтална.

1.5.Хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүчирхийлэгчид хууль ёсны шаардлага, анхааруулга өгөх, хүчирхийллийн аюулын зэргийг тодорхойлох, хүчирхийлэгчийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах үйл ажиллагаа / цаашид “Аюулын зэргийн үнэлгээ” гэх/ -г цагдаагийн алба хаагч хэрэгжүүлнэ.

Хоёр. Аюулын зэргийн үнэлгээ хийх

2.1.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэлд очсон цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээг хийнэ.

2.2.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй нөхцөл байдалд аюулын зэргийн үнэлгээ хийх шаардлагагүй.

2.3.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг удаа дараа ирүүлсэн хохирогчид аюулын зэргийн үнэлгээг заавал хийнэ.

2.4.Аюулын зэргийн үнэлгээг дараах байдлаар ангилна:

2.4.1.Бага;

2.4.2.Дунд;

2.4.3.Өндөр.

2.5.Аюулын зэргийн бага түвшин гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчийн зөвшөөрөлгүй уулзах, харилцаа тогтоохыг оролдсон, сэтгэл санааны дарамтад оруулсан, хүүхдийн хүмүүжилд хохирол учруулсан, эдийн засгийн дарамтад оруулсан нөхцөл байдлыг ойлгоно.

2.6.Аюулын зэргийн дунд түвшин гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүдийг айлган сүрдүүлсэн, дарамталсан, дагаж мөшгисөн, ятгасан нөхцөл байдлыг ойлгоно.

2.7.Аюулын зэргийн өндөр түвшин гэж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийн амь насанд нь бодитой заналхийлсэн, бие махбодид гэмтэл учруулсан, эсхүл учруулж болзошгүй, хүчирхийлэл даамжирсан, байнгын дарамтад байлгасан, хүчирхийлэл үйлдэгч нь гадны биет буюу галт зэвсэг хэрэглэдэг, эсхүл хэрэглэж болзошгүй болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй

тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлыг ойлгоно.

2.8.Аюулын зэргийн үнэлгээг батлагдсан маягт /Маягт №28/-аар үнэлэх ба үнэлгээ хийх заавар дахь онцгой нөхцөлд дурдсан нөхцөл байдлуудыг аюулын зэргийн үнэлгээг “дунд”, “өндөр” гэж үнэлэхэд анхаарч үзэх шаардлагатай.

2.9.Хүүхдийн аюулын зэргийн үнэлгээг батлагдсан маягт /Маягт №28/-аар үнэлэх ба үнэлгээ хийх заавар дахь онцгой нөхцөлд дурдсан нөхцөл байдлуудыг аюулын зэргийн үнэлгээг “дунд”, “өндөр” гэж үнэлэхэд анхаарч үзэх шаардлагатай.

2.10.Маягт нь гэр бүлийн хүчирхийллийн бодит байдлыг тодорхойлох нийт 20 асуултаас бүрдэх ба цагдаагийн алба хаагч зөвхөн өөрөө бөглөнө.

2.11.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажиллаж буй цагдаагийн алба хаагч хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдлийг таслан зогсоож, хүчирхийлэгчийг хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдээс тусгаарлах, аюулгүй болгох арга хэмжээ авсны дараа хохирогчоос асуулгын дагуу тодруулах, хүчирхийлэл үйлдэгдсэн орчин, эсхүл үйлдэгдсэн байж болох орчны нөхцөл байдлыг судлах, харьцуулах байдлаар үнэлгээ хийнэ.

2.12.Аюулын зэргийн үнэлгээг хийхийн өмнө хохирогчийн эрх, үүргийг болон нөхцөл байдлыг үнэн зөв хариулах талаар тайлбарлан өгч, үнэлгээ хийгдсэнээр гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэхэд хүчирхийлэгчид авах арга хэмжээ, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний төрлийг сонгоход чухал ач холбогдолтойг тайлбарлаж өгнө.

2.13.Аюулын зэргийн үнэлгээ хийхдээ хохирогчийг буруутгах, нэг талыг баримтлахгүй, тулгах, хөтлөх байдлаар асуулт тавихыг хориглоно.

2.14.Цагдаагийн алба хаагч албан тушаал, цол, нэр, үнэлгээ хийсэн он, сар, өдөр, газрын хаяг, хүчирхийлэлд өртсөн хохирогч болон хүчирхийлэгчийн овог нэр, регистрийн дугаарыг бичиж асуулгыг үргэлжлүүлнэ.

2.15.Аюулын зэргийн үнэлгээг хийхдээ асуултын өмнөх “тийм” эсвэл “үгүй” гэсэн баганад оноо тавих ба “тийм” гэсэн хариулт тус бүрт 1 оноо, “үгүй” гэсэн хариулт тус бүрт 0 оноо тавина. Үнэлгээг гаргаж дууссаны дараа “тийм” гэсэн хариултын нийлбэр оноог гаргаж, 0-6 оноог бага, 7-12 оноог дунд, 13-20 оноог өндөр гэж үнэлэх ба нийлбэр оноо гэсэн хэсэгт оноог бичиж, тохирох үнэлгээний доогуур зурж баталгаажуулна.

2.16.Цагдаагийн алба хаагч гарын үсэг зурж баталгаажуулсан аюулын зэргийн үнэлгээг хохирогчид танилцуулж гарын үсэг зуруулна.

2.17.Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийн дагуу ажилласан цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээг холбогдох материалын хамт шийдвэрлүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэж өгнө.

2.18.Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан аюулын зэргийн үнэлгээ, холбогдох материалын хамт хүлээн аваад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан арга хэмжээг авна.

2.19.Хүүхдэд аюулын зэргийн үнэлгээ хийгдсэн тохиолдолд харьяа гэр бүл, хүүхэд, хөгжлийн байгууллагад хүргүүлж хамтран ажиллах арга хэмжээ авна.

Гурав.Бусад

3.1.Энэ журмын хэрэгжилтэнд эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

--- о0о ---

Маягт № 28

Аюулын зэргийн үнэлгээний загвар, оноо дүгнэх аргачлал

АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээ хийсэн	Байгууллагацагдаагийн газар, хэлтсийналбан тушаалтай, цолтой
	Огноо, газарон..... сар өдөрцаг... минутаймаг, дүүрэг
Хүчирхийллийн хохирогч	овог.....нэр регистр
Хүчирхийлэл үйлдэгч	овог.....нэррегистр

Асуултын өмнөх “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн баганад оноо тавих ба “тийм” гэсэн хариултад “1” оноо, “үгүй” гэсэн хариултад “0” оноо тавина.

Тийм	Үгүй	Хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуулт
		1.Хүчирхийлэгч хохирогчийг байнга хардаж, мөрдөж мөшгидэг эсэх. жишээ нь: араас нь дагах эсвэл мөрдөх, гар утсанд сүрдүүлсэн мессеж үлдээх, түүнтэй ярихыг хүсэхгүй үед олон дахин утсаар залгадаг эсэх.
		2.Хүчирхийлэгч хохирогчийг гэрээс гаргахгүй нийгмийн харилцаанаас тусгаарлаж, эцэг, эх, хамаатан садан, найз нөхөдтэйгээ уулзахад саад учруулдаг эсэх.
		3.Өнгөрсөн нэг жилийн хугацаанд хохирогч хүчирхийлэгчээс салах оролдлого хийж байсан эсэх.
		4.Хохирогч хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй эсэх.
		5.Хүчирхийлэгч согтууруулах, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэдэг эсэх.
		6.Хүчирхийлэгч хохирогч, гэр бүлийн бусад гишүүдийг байнга шүүмжилж эсвэл аливаа үйлдлийг нь буруушааж, гутаан доромжлох зэргээр хүчирхийлэл үйлддэг эсэх.
		7.Хүчирхийлэгч хохирогчийн гар утас, эд зүйл, эсхүл гэр бүлийн эд хогшлийг эвдэж устгах, эсхүл эвдэж устгахаар сүрдүүлдэг эсэх.
		8.Хохирогч урьд өмнө цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн тухай дуудлага, мэдээлэл өгч байсан эсэх.
		9.Хүчирхийлэгч урьд өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтны урьдчилан сануулга, шаардлага, эрх хязгаарлах зэрэг хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг зөрчиж байсан эсэх.
		10.Хохирогч болон түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдэд бэлгийн хүчирхийлэл үйлдэж байсан эсэх, эсхүл бэлгийн дарамтад оруулж байсан эсэх.
		11.Хохирогч хүчирхийлэгчийн эсрэг гаргасан гомдлоосоо татгалзаж, хуулийн байгууллагад тавьсан гомдлоо хүчирхийлэгчид ашигтайгаар шийдвэрлүүлж байсан эсэх.
		12.Хүчирхийлэгч нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд стресс, сэтгэл санааны хямралд орж байсан эсэх. /ажилгүйдэл, ойр дотны хүний үхэл, санхүүгийн хямрал, өр зээл г.м/
		13.Өнгөрсөн нэг жилийн хугацаанд бие махбодийн хүчирхийлэл даамжирч эмнэлгийн тусламж авахад хүргэсэн гэмтэл учруулж, үйлдлийн давтамж ойртсон эсэх.
		14.Хүчирхийлэгч хохирогчийг олохын тулд хүүхдээ холбоо тогтоох хэрэгсэл болгон ашигладаг, эсхүл хэн нэгнийг барьцаалж заналхийлдэг эсэх.
		15.Хохирогчийн эсрэг урьд өмнө зэвсгийн чанартай эд зүйлс, хутга, галт зэвсэг хэрэглэж, заналхийлж байсан эсэх.
		16.Хохирогчийг жирэмсэн байх үед гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж

	байсан эсэх.
	17.Төв, суурин газраас алслагдсан, эсхүл тусламж авах боломжгүй үдэш, оройн цагаар хүчирхийлэл үйлдэгддэг эсэх.
	18.Хүчирхийлэгч өөрийгөө алах оролдлого хийн сүрдүүлж байсан эсэх.
	19.Хохирогчийг багалзуурдах, амьсгалыг нь боох, түлэх, живүүлэх зэргээр алах оролдлого хийж байсан эсэх.
	20. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч өөрийнхөө амийг егүүтгэх оролдлого хийж байсан эсэх.
“Тийм” гэсэн хариултын нийлбэр оноог гаргаж, үнэлгээг доогуур зурах. Нийлбэр оноо: /бага, дунд, өндөр/	
Аюулын зэргийн үнэлгээ хийсэн: Цагдаагийн алба хаагч //	
Аюулын зэргийн үнэлгээтэй танилцсан: Хохирогч /...../	

---oOo---

ХОХИРОГЧИЙН АЮУЛЫН ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг дүгнэхэд “тийм” гэсэн хариултад 1 оноо, “үгүй” гэсэн хариултад 0 оноо тавина.

1. Аюулын зэргийн бага үнэлгээ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултад 0-6 оноо өгсөн тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг “бага” гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, байнга зодсон, харгис хэрцгий хандсан, догшин авирласан, хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэл үйлдэгч зэвсгийн чанартай эд зүйлс, хутга, галт зэвсэг хэрэглэсэн, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг бага гэж үзэхгүй. Энэ тохиолдолд дунд буюу өндөр үнэлгээ өгч болохыг тодорхойлно.

2. Аюулын зэргийн дунд үнэлгээ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултад 7-12 оноо өгсөн тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг “дунд” гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, байнга зодсон, харгис хэрцгий хандсан, догшин авирласан, хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй улмаас хүчирхийлэл үйлдэгчээс хамааралтай хүний эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэл үйлдэгч зэвсгийн чанартай эд зүйлс, хутга, галт зэвсэг хэрэглэсэн, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан, эсхүл хохирогч нэн даруй хууль сахиулах байгууллага, эрүүл мэндийн тусламж авах боломжгүй тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг дунд гэж үзэхгүй. Энэ тохиолдолд дунд буюу өндөр үнэлгээ өгч болохыг тодорхойлно.

3. Аюулын зэргийн өндөр үнэлгээ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултад 13-20 оноо өгсөн тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг “өндөр” гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Хүчирхийллийг хохирогч түүний хүүхдэд, гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй, хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй, хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, эсхүл ашиглаж болзошгүй, хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй, хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг, хохирогчийг байнга зодсон, харгис хэрцгий хандсан, догшин авирласан, тохуурхан даажигнасан, тарчлаасан, хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг хүчирхийлэл үйлдсэн, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг өндөр гэж тодорхойлж хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч, хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалах арга хэмжээ авна.

---oOo---

Маягт № 29

Хүүхдийн аюулын зэргийн үнэлгээний загвар, оноо дүгнэх аргачлал.

ХҮҮХДИЙН АЮУЛЫН ЗЭРГИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээ хийсэн	Байгууллагацагдаагийн газар, хэлтсийналбан тушаалтай, цолтой
	Огноо, газарон..... сар өдөрцаг... минутаймаг, дүүрэг
Хүчирхийллийн хохирогч хүүхэд	овог.....нэр регистр
Хүчирхийлэл үйлдэгч	овог.....нэррегистр
Асуултын өмнөх “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн баганад оноо тавих ба “тийм” гэсэн хариултад “1” оноо, “үгүй” гэсэн хариултад “0” оноо тавина.		
Тийм	Үгүй	Хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуулт
		1.Хүчирхийлэгч нь хүүхдийн зайлшгүй шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх, хоол унд, хувцас, орон гэрээр гачигдуулдаг эсэх.
		2.Хүүхдээр тэвчишгүй хүнд хөдөлмөр хийлгүүлдэг, эсхүл хүүхдийн эмзэг байдлыг ашиг олох хэрэгсэл болгодог эсэх.
		3.Хүүхдийн асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй, хүнд болон сэтгэцийн өвчний улмаас хүчирхийлэгчээс хүүхдийг хамгаалах чадваргүй байгаа эсэх.
		4.Хүүхэд 0-6 настай, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй, өөрийгөө хамгаалах, бусдаас тусламж хүсэх, аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх чадваргүй эсэх.
		5.Хүүхэд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэйгээ амьдардаггүй, эсхүл хагас болон бүтэн өнчин, дагавар, өргөмөл эсэх.
		6.Хүүхдийг гэрээс гаргахгүй бусдаас тусгаарлах, сургууль завсардуулах үйлдэл гаргасан эсэх.
		7.Хүүхэд урьд өмнө гэмт хэрэг, зөрчилд холбогдож байсан эсэх.
		8.Хүчирхийллийн улмаас хүүхэд гэрээсээ оргон зугтаж байсан эсэх.
		9.Хүүхдийн амьдарч буй орчин нь гэр бүлийн хүчирхийлэлтэй, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эрсдэлтэй эсэх.
		10. Хүчирхийлэгч хүүхдийг байнга шүүмжилж эсвэл аливаа үйлдлийг нь буруушааж, гутаан доромжилдог эсэх.
		11.Хүчирхийлэгч нь урьд өмнө хүүхдийг гомдлоос татгалзуулах буюу түүний мэдүүлгийг өөрчлүүлэхээр заналхийлж байсан эсэх.
		12.Хүчирхийлэгч нь өөрийгөө хянах чадваргүй, догшин ширүүн зан авиртай эсэх.
		13.Хүчирхийлэгчээс хүүхдэд учирсан гэмтлийг бодит байдлаас зөрүүтэй, итгэл үнэмшилгүй тайлбарлаж буй эсэх.
		14.Хүчирхийлэгч гэртээ байнга болон хүүхдийн дэргэд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэдэг эсэх.
		15.Хүүхдийн бие махбодид ноцтой гэмтэл илэрсэн, хүчирхийллийн давтамж ойртсон эсэх.
		16.Хүүхдийг барьцаалж гэр бүлийн бусад гишүүдийг олох, уулзах арга хэрэгсэл болгодог эсэх.
		17.Хүүхдийг алахаар зэвсгийн чанартай эд зүйлс, хутга, галт зэвсэг хэрэглэж, айлган сүрдүүлж байсан эсэх.
		18.Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл болзошгүй нөхцөл байдалд байгаа эсэх.

		19.Хүчирхийлэгч нь сэтгэцийн өвчний улмаас бусдын болон өөрийн амь насанд аюултай үйлдэл гаргаж байсан эсэх.
		20.Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд амиа хорлох оролдлого хийж байсан эсэх.
“Тийм” гэсэн хариултын нийлбэр оноог гаргаж, үнэлгээг доогуур зурах. Нийлбэр оноо:		
/бага, дунд, өндөр/		
Аюулын зэргийн үнэлгээ хийсэн: Цагдаагийн алба хаагч		
/...../		
Аюулын зэргийн үнэлгээтэй танилцсан:		
Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч.....		
/...../		

---oOo---

ХҮҮХДИЙН АЮУЛЫН ЗЭРГИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг дүгнэхэд “тийм” гэсэн хариултад 1 оноо, “үгүй” гэсэн хариултад 0 оноо тавина.

1. Аюулын зэргийн бага үнэлгээ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултад 0-6 оноо өгсөн тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг “бага” гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, байнга зодсон, амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг бага гэж үзэхгүй. Энэ тохиолдолд дунд буюу өндөр үнэлгээ өгч болохыг тодорхойлно.

2. Аюулын зэргийн дунд үнэлгээ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултад 7-12 оноо өгсөн тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг “дунд” гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Гэр бүлийн хүчирхийлэл даамжирсан, байнга зодсон, амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг, хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, хүүхэд бага насны, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй, өөрийгөө хамгаалах, бусдаас тусламж хүсэх, аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх чадваргүй тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг дунд гэж үзэхгүй. Энэ тохиолдолд өндөр үнэлгээ өгч болохыг тодорхойлно.

3. Аюулын зэргийн өндөр үнэлгээ.

Гэр бүлийн хүчирхийллийн аюулын зэргийг тодруулах асуултад 13-20 оноо өгсөн тохиолдолд хохирогчийн аюулын зэргийн үнэлгээг “өндөр” гэж үнэлнэ.

Онцгой тохиолдол: Хүчирхийллийг хохирогч түүний хүүхдэд, гэр бүлийн бусад гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй, хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй, хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, эсхүл ашиглаж болзошгүй, хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй, хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм, бодис хэрэглэдэг, хохирогчийг байнга зодсон, харгис хэрцгий хандсан, догшин авирласан, тохуурхан даажигнасан, тарчлаасан, хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, архаг хууч өвчтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг хүчирхийлэл үйлдсэн, мөн хүчирхийллийн улмаас хохирогчийн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдсан буюу бие махбодид хүнд гэмтэл учирсан тохиолдолд аюулын зэргийн үнэлгээг өндөр гэж тодорхойлж хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч, хохирогч, түүний хүүхэд, гэр бүлийн бусад гишүүдийг хамгаалах арга хэмжээ авна.

